

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/13/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: З.Ганбаатар Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 69

танай _____ ны № _____ т

АЙМГИЙН МУЗЕЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.ХАЛИУНАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020100

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,399,461.70	8,789,028.70
35	БАРАА МАТЕРИАЛ	9,399,461.70	8,789,028.70
354	Хангамжийн материал	9,399,461.70	8,789,028.70
35410	Бичиг хэргийн материал	690,900.70	223,400.70
35420	Аж ахуйн материал	8,644,961.00	8,502,028.00
35450	Барилгын засварын материал	55,000.00	55,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,600.00	8,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	576,976,185.39	963,621,980.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	576,976,185.39	963,621,980.38
392	Биет хөрөнгө	521,810,185.39	908,455,980.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	118,279,930.00	524,077,510.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,934,058.56)	(42,466,887.84)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,666,666.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,884,062.00	24,484,062.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,149,241.06)	(10,900,143.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,627,590.75	36,627,590.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,884,114.38)	(11,712,249.35)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	383,753,500.00	384,803,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	279,020.00	279,020.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(46,503.36)	(69,755.04)
393	Биет бус хөрөнгө	55,166,000.00	55,166,000.00
39301	Програм хангамж	184,800.00	184,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(184,800.00)	(184,800.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	55,166,000.00	55,166,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	586,375,647.09	972,411,009.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	586,375,647.09	972,411,009.08
51	Засгийн газрын хувь оролцоо	586,375,647.09	972,411,009.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	139,581,068.34	139,581,068.34
51101	Өмч: - төрийн	139,581,068.34	139,581,068.34
512	Хуримтлагдсан үр дүн	51,785,904.02	437,821,266.01
51210	Өмнөх үеийн үр дүн	51,785,904.02	51,785,904.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	386,035,361.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	395,008,674.73	395,008,674.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	586,375,647.09	972,411,009.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	205,495,012.00	618,399,180.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	180,427,412.00	406,847,580.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,500,412.00	405,797,580.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,500,412.00	405,797,580.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,500,412.00	405,797,580.00

**Булган аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

122	Тусламжийн орлого	-	1,050,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	1,050,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	154,927,000.00	-
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	154,927,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,067,600.00	211,551,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,067,600.00	211,551,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,067,600.00	211,551,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	194,541,107.60	232,363,818.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	194,541,107.60	232,363,818.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	168,726,628.63	172,786,115.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	103,896,068.47	101,902,820.00
210101	Үндсэн цалин	82,294,432.00	81,869,032.00
210102	Нэмэгдэл	21,601,636.47	20,033,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,988,579.96	12,992,047.42
210201	Тэтгэврийн даатгал	9,591,510.42	9,192,328.24
210202	Тэтгэмжийн даатгал	980,593.52	1,019,028.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	626,716.31	815,222.43
210204	Ажилгүйдлийн даатгал	166,716.11	171,108.31
210205	Эрүүл мэндийн даатгал	1,623,043.60	1,794,360.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,303,651.00	25,326,206.30
210301	Гэрэл, цахилгаан	1,900,451.00	1,343,006.30
210302	Түлш, халаалт	27,403,200.00	23,983,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,744,521.60	2,937,532.00
210401	Бичиг хэрэг	582,750.00	784,180.00
210402	Тээвэр, шатахуун	1,023,900.00	756,954.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	787,971.60	972,898.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	167,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	349,900.00	256,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,018,000.00	4,080,000.00
210604	Урсгал засвар	1,018,000.00	4,080,000.00
2107	Томилолт, зочны зардал	253,800.00	192,000.00
210702	Дотоод албан томилолт	253,800.00	192,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,602,927.00	3,553,725.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,221,927.00	2,662,873.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	90,500.00	78,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	66,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	675,000.00
210807	Газрын төлбөр	-	38,352.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,919,080.60	21,801,785.01
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,919,080.60	21,801,785.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,814,478.97	59,577,702.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,065,948.00	54,697,729.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	52,281,729.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,065,948.00	2,416,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	748,530.97	4,879,973.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	748,530.97	4,879,973.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=- (1)-(2)	10,953,904.40	386,035,361.99
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	265,012.13	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	265,012.13	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=- (145-225)	(265,012.13)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,688,892.27	386,035,361.99

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	3,027,935,582.22	8,551,449,341.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	185,618.00	185,618.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	3,027,935,582.22	8,551,634,959.49
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-		
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-48,791,634.36	-48,791,634.36
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	2,979,329,565.86	8,502,843,325.13
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	2,979,329,565.86	8,502,843,325.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	35,035,300.80	35,035,300.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	3,014,364,866.66	8,537,878,625.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-35,035,300.80	00.00	-35,035,300.80
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	279,141,723.39	279,141,723.39
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	385,188,324.97	3,293,506,590.05	8,781,985,048.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	180,056,600.00	211,551,600.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	62,000.00	-
110	Орлогын албан татвар	62,000.00	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	62,000.00	-
110002	Үйл ажиллагааны орлого	62,000.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	154,927,000.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	154,927,000.00	-
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	154,927,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,067,600.00	211,551,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,067,600.00	211,551,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,067,600.00	211,551,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	180,056,600.00	209,951,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180,056,600.00	209,951,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,242,121.03	150,373,897.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	103,896,068.47	101,902,820.00
210101	Үндсэн цалин	82,294,432.00	78,920,129.00
210102	Нэмэгдэл	21,601,636.47	22,982,691.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,988,579.96	12,992,047.42
210201	Тэтгэврийн даатгал	9,591,510.42	9,192,328.24
210202	Тэтгэмжийн даатгал	980,593.52	1,019,028.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	626,716.31	815,222.43
210204	Ажилгүйдлийн даатгал	166,716.11	171,108.31

Булган аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	1,623,043.60	1,794,360.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,303,651.00	25,326,206.30
210301	Гэрэл, цахилгаан	1,900,451.00	1,343,006.30
210302	Түлш, халаалт	27,403,200.00	23,983,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,001,421.60	2,775,372.00
210401	Бичиг хэрэг	639,950.00	525,080.00
210402	Тээвэр, шатахуун	1,023,900.00	756,954.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	987,671.60	985,338.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	258,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	349,900.00	250,000.00
2105	Нормативт зардал	159,200.00	159,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	159,200.00	159,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,290,000.00	4,300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	-
210604	Урсгал засвар	1,190,000.00	4,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	253,800.00	192,000.00
210702	Дотоод албан томилолт	253,800.00	192,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,349,400.00	2,726,252.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,968,400.00	1,746,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	95,000.00	78,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	66,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	764,100.00
210807	Газрын төлбөр	-	38,352.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,814,478.97	59,577,702.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,065,948.00	54,697,729.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,067,548.00	52,281,729.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	998,400.00	2,416,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	748,530.97	4,879,973.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	748,530.97	4,879,973.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,600,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,600,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,600,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,600,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	211551045.00	206671626.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	211551045.00	205071626.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158805445.00	150373897.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106127300.00	101902820.00
210101	Үндсэн цалин	84694200.00	78920129.00
210102	Нэмэгдэл	21433100.00	22982691.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14326545.00	12992047.42

Булган аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	10082100.00	9192328.24
210202	Тэтгэмжийн даатгал	1061127.00	1019028.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	849018.00	815222.43
210204	Ажилгүйдлийн даатгал	212200.00	171108.31
210205	Эрүүл мэндийн даатгал	2122100.00	1794360.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29703200.00	25326206.30
210301	Гэрэл, цахилгаан	2300000.00	1343006.30
210302	Түлш, халаалт	27403200.00	23983200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2901500.00	2775372.00
210401	Бичиг хэрэг	533300.00	525080.00
210402	Тээвэр, шатахуун	760200.00	756954.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	985,338.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	258,000.00	258,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	250,000.00
2105	Нормативт зардал	159,200.00	159,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	159,200.00	159,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	4,300,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	4,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	259,700.00	192,000.00
210702	Дотоод албан томилолт	259,700.00	192,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,228,000.00	2,726,252.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,645,800.00	1,746,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	78,500.00	78,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,500.00	66,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	764,100.00
210807	Газрын төлбөр	45,200.00	38,352.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,745,600.00	54,697,729.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,745,600.00	54,697,729.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,328,900.00	52,281,729.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	2,416,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,600,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	211,551,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	211,551,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	211,551,600.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Аудитор З.Ганбатаар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймгийн Музей нь “Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, үндэсний өв уламжлалыг залгамжлан, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагыг хослуулан хөгжүүлнэ.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах 4 зорилт, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд 18 ажил төлөвлөж гүйцэтгэлээр 100 хувь байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Музейн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс нь 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 194.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 386,035.4 мянган төгрөгөөр буюу 65.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	9,399,461.70	8,789,028.70	(610,433.00)
Үндсэн хөрөнгө	576,976,185.39	963,621,980.38	386,645,794.99
Нийт хөрөнгө	586,375,647.09	972,411,009.08	386,035,361.99
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	586,375,647.09	972,411,009.08	386,035,361.99
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	586,375,647.09	972,411,009.08	386,035,361.99

Авлага: Тайлант онд авлага үүсээгүй байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 9,399.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 8,789.0 сая төгрөг болж өмнөх оноос 610.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 963,621.9 мянган төгрөг болж 386,645.8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр: Тайлант онд өр төлбөр үүсээгүй болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 211.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 211.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 20 төсөл хөтөлбөрийн 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 211.6 сая төгрөгийн төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 211.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 0 бусад орлого 406.8 сая төгрөг нийт 618.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 613.6 сая төгрөгийг зарцуулж 4.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого төвлөрөөгүй болно.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд Батлагдсан төсвөөс төсвийн хэмнэлт гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш 13 удаагийн 208,705.8 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна. Энэ нь Шилэн дансны тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Анхан шатны баримтгүй 60,000.0 төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтад заасан мэдээллийг мэдээлээгүй нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 1,109.5 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 306.4 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 160.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 146.4 төгрөгийн 2 төлбөрийн актыг тогтоож, алдаа зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага өгч ажиллаа.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 160.0 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Тайлант анхан шатны баримтын бүрдэлгүй 60.0 мянган төгрөгийг зарцуулсан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Төлбөрийн акт

Тайлант онд 86,400.0 төгрөгийн тэмцээний шагнал олгосон нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.6, "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.4 Албан шаардлага

Таван сая төгрөгөөс дээш 13 удаагийн 208,705,800.0 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дэх заалтыг зөрчсөн байна. Энэ нь Шилэн дансны тухайн

хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мян.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Музей	4	306.4	1	160.0	2	146.4	1	0	0	0
	Нийт дүн	4	306.4	1	160.0	2	146.4	1	0	0	0